



**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016 он

Агуулга



1. Компанийн товч танилцуулга	2
1.1 Байгууллагын бүтэц зохион байгуулалт.....	3
2. Удирдлагын талаарх мэдээлэл	4
2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт	4
2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)	4
2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ).....	5
2.4 Гүйцэтгэх удирдлага.....	8
2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл	9
3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл	10
3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр	10
3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл	10
4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл	11
5. Санхүүгийн талаарх мэдээлэл	11

1. Компанийн товч танилцуулга

“Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК нь 2006 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Монголбанк, Анод банк, Голомт банк, Зоос банк, Капитал банк, Капитрон банк, Монгол шуудан банк, Хаан банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкны оролцоотойгоор байгуулагдсан. Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, орон сууцны санхүүжилтийн урт хугацаат тогтолцоог хөгжүүлэх үүднээс санхүүгийн зах зээлийн хэрэгслүүд ашиглан дотоод гадаадын зах зээлээс дунд болон урт хугацааны санхүүжилт татан нэмэгдүүлэх замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг дэмжих зорилготой ажилладаг.


Монгол Улсад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль анх 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр батлагдаж, үнэт цаас гаргах хууль, эрх зүйн орчин 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр бий болсон. “МИК ОССК” ХХК-ийн охин компани нь 2012 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авч нэрээ “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК болгон өөрчилсөн. Мөн “МИК ОССК” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2013 оны 12 дугаар сарын 16-нд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, одоогийн байдлаар Монгол Улсад Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрхтэй цорын ганц хуулийн этгээд болсон.

“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг үүсгэн байгуулж, “МИК ОССК” ХХК-ийн толгой компани болгон бүтцийг нь өөрчилж, “МИК ОССК” ХХК-ийн хувьцааг “МИК Холдинг” ХХК-д шилжүүлэх шийдвэр гаргасан. 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “МИК Холдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг нээлттэй ХК болгон өөрчилснөөр 2015 онд 12 хувьцаа эзэмшигчтэй байсан. “МИК Холдинг” ХК болж 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 104, 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нийт 98 хувьцаа эзэмшигчтэй болоод байна.





1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт



2. Удирдлагын талаарх мэдээлэл

2.1 Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

“МИК Холдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг “МИК Холдинг” ХК болгон өөрчлөх, бүтцийг батлах шийдвэрийн дагуу “МИК ОССК” ХХК-ийн бүтэц дэх Дотоод аудит, ТУЗ-ийн ажлын албыг “МИК Холдинг” ХК-ийн бүтэц рүү 2016 оны эхний улиралд шилжүүлэв. Ийнхүү шилжүүлсэн хэдий ч эдгээр алба нь “МИК Холдинг” ХК, “МИК ОССК” ХХК болон түүний охин компаниуд болох МИК Актив Нэгээс Ес хүртэлх ТЗК-иудын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор “МИК ОССК” ХХК-тай ажлын хэлхээ холбоогоо хадгалан хамтран ажиллаж байна.

“МИК Холдинг” ХК нь 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар байнгын ажлын байранд үндсэн 8 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

“МИК Холдинг” ХК-ийн бүтэц дэх албан тушаал, ажилтны тоо:

Гүйцэтгэх захирал	1
ТУЗ-ийн Ажлын албаны дарга	1
Ахлах аудитор	1
Дотоод аудитор	2
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1
ТЗК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	2

2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

“МИК Холдинг” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл болон Компанийн Дүрмийн дагуу ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд жилд нэг удаа зарлан хуралдуулдаг. МИК Холдинг ХК- нь нийт 12 хувьцаа эзэмшигчтэй байсан бол ХК болсноор Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв /ҮЦТТТХТ/-ийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн мэдээгээр нийт 104 хувьцаа эзэмшигчтэй болоод байна.



2.3 Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаас бусад тохиолдолд Компанийн удирдлага болон бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн засаглалын олон улсын жишигт нийцүүлэн Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл нь 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнтэйгээр ажиллаж байна.



Төлөөлөн удирдах зөвлөл нь ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулан хуралддаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хэдийгээр 9 гишүүнтэй ч Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаатай нээлттэй ил тод танилцах, асуудлыг зөв шийдвэрлүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөлгүй Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодод гишүүнээр ажиллуулж байна.

ТУЗ-ийн гишүүдийн товч мэдээлэл

М.Мөнхбаатар нь Улаанбаатар Хотын банкны Дэд захирал бөгөөд “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн даргаар 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Тэрээр мөн ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны даргаар ажилладаг.

Д.Болдбаатар нь Монголбанкны Мөнгөний бодлого, Судалгааны газрын Захирал бөгөөд “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ажилладаг.

Б.Буянмөнх нь Хөгжлийн банкны орлогч захирал бөгөөд хөрөнгө оруулалтын газрын Захирал бөгөөд “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагаа, эрх зүйн хорооны даргаар ажилладаг.

Д.Сугар нь Голомт банкны Дэд захирал ба Бизнес хөгжлийн газрын захирлаар ажилладаг бөгөөд “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хорооны гишүүнээр ажилладаг.



Л.Гантөмөр нь Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар ажилладаг. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Г.Хүрэлбаатар нь “Юнайтед Секьюритс” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү аудитын хорооны гишүүнээр ажилладаг.

Э.Шижир нь “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Санхүү, аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Д.Байлхүү нь Азийн Хөгжлийн банкны төр хувийн хэвшлийн түншлэлийн төслийн багийн зөвлөхөөр ажилладаг. Тэрээр “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагаа, эрх зүйн хороо болон Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

Ц.Цолмон нь “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2016 оны 03-р сарын 07-нд сонгогдсон. Мөн ТУЗ-ийн Үйл ажиллагаа эрх зүйн хороо болон, Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүнээр тус тус ажилладаг.

ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

Компанийн засаглалын зөв бодлого, зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол өгч ажилладгийн хувьд Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурал, түүний дэргэдэх хороодын хурлыг тогтмол зохион байгуулж, эрх хэмжээний хүрээнд асуудлыг шийдвэрлүүлэн ажилладаг. МИК Холдинг ХК-ийн ТУЗ-ийн дэргэд Санхүү, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Үйл ажиллагаа, эрх зүйн хороо, Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хороо гэсэн 4 хороо үйл ажиллагаа явуулж байна.



Санхүү аудитын хороо нь

ТУЗ-д удирдах чиглүүлэх болон хянан шалгах үүргээ үр ашигтай бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслах, ялангуяа компанийн санхүүгийн тайлан, дотоод хяналтын бодлого журмын үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулах, хөндлөнгийн болон дотоод аудитортой харилцан ажиллах нягтлан бодох бүртгэл, санхүүгийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт өгөх, мэдээлэл зөвлөмжөөр хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын хороо нь

Компанийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд зах зээлийн болон зээлийн эрсдэлийг урьдчилан тооцож, ТУЗ-өөс баталж өгсөн компанийн төлөвлөгөөний хэрэгжилтэд зэрэг учирч болох олон талт эрсдлээс хамгаалах дүгнэлт гаргах, эрсдлээс хамгаалах бодлого, журмыг хэрэгжүүлэхэд хяналт тавир, зөвлөмж мэдээллээр хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Үйл ажиллагаа эрх зүйн хороо нь

Компанийн үйл ажиллагааны стратегийн төлөвлөлт түүний хэрэгжилт, үйл ажиллагааны дүрэм журам, гэрээ хэлцэл, эрх зүйн орчин бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх шаардлагатай мэдээлэл зөвлөмжөөр хангах, дүгнэлт гаргах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо нь

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох бүрэн эрхийн хугацааг цуцлах болон сунгах, компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлого тодорхойлох, компанийн хүний нөөц бүрдүүлэх, ажиллагсдыг тогтвортой үр бүтээлтэй ажиллуулах чиглэлээр асуудал хэлэлцэх, дүгнэлт гаргах чиг үүрэг хэрэгжүүлдэг.



№	Хороо	Гишүүдийн тоо	Гишүүд	Албан тушаал
1	Санхүү, аудитын хороо	5	Э.Шижир Д.Сугар Б.Дэлгэржаргал Л.Гантөмөр Г.Хүрэлбаатар	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
2	Эрсдэлийн удирдлагын хороо	4	Д.Болдбаатар Д.Зоригт Ц.Ганзориг Л.Гантөмөр	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн
3	Үйл ажиллагаа, эрх зүйн хороо	5	Б.Буянмөнх М.Оюунтуяа Б.Баяраа Д.Байлхүү Ц.Цолмон	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн Гишүүн
4	Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо	4	М.Мөнхбаатар Э.Шижир Д.Байлхүү Ц.Цолмон	Дарга Гишүүн Гишүүн Гишүүн

2.4 Гүйцэтгэх удирдлага

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал буюу Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнана. “МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрхийн хүрээнд дараах эрхийг хэрэгжүүлнэ:

- Компанийн Гүйцэтгэх захирлын хувиар Компанийн болон бизнес хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар ТУЗ-д саналаа танилцуулж, чиглэл авч Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх;



- Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, хууль тогтоомжид заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй зэрэг хэлцэл хийх тохиолдолд тухай бүрт нь ТУЗ-аас олгосон итгэмжлэлийн дагуу оролцох;
- Компанийн хөрөнгийн удирдлага, өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанаас бусад компанийн хөрөнгө оруулалт, бусад эд хөрөнгө худалдах, худалдан авах зэрэг хэлцлийг ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хийх.

“МИК Холдинг” ХК болон “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Гантөгс нь эдийн засагч мэргэжилтэй, 1983-1988 онд Герман улсын “University of Applied Science, Berlin, FRG”-ийг эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Ажлын туршлагын хувьд Худалдаа хөгжлийн банкинд зээлийн эдийн засагч, төслийн удирдагч, Хаан банк, Капитрон банк, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар хотын банкинд Дэд захирлаар тус тус ажиллаж байсан. Тэрээр 2013 оны 05 дугаар сард “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон ба бусдад ямар нэгэн өр зээлгүй, ял шийтгэлгүй, хууль хяналтын байгууллагад үүсгэн шалгагдаж байгаа зөрчилгүй болно.

2.5 Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Иргэний харьяалал
1	Д.Гантөгс	Гүйцэтгэх захирал	Монгол
2	Ж.Оюун	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албаны дарга	Монгол
3	Г.Саруул	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	Монгол



3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал түүний шийдвэр

- ✓ “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2016 оны 16/01 тоот шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож баталсан. Хуралдаанд нийт хувьцаа эзэмшигчид 98,63 хувийн ирцтэй оролцсон.

- ✓ “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2016 оны 16/24 тоот шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хуралдсан бөгөөд тус хурлаар Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт болон ТУЗ-ийн зардлын төсвийг тус тус хэлэлцэж баталсан. Хуралдаанд нийт хувьцаа эзэмшигчид 96,24 хувийн ирцтэй оролцсон.

3.2 Нөлөө бүхий Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “МИК Холдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “МИК Холдинг” ХХК-ийг нээлттэй ХК болгон өөрчилснөөр 2015 онд 12 хувьцаа эзэмшигчидтэй байсан “МИК Холдинг” ХХК нь “МИК Холдинг” ХК болсноор 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нийт 98 хувьцаа эзэмшигчидтэй болоод байна. Үүнээс Компанийн нийт хувьцааны 19,31 хувийг Төрийн өмчит байгууллагууд, 80,63 хувийг Аж ахуй нэгжүүд, 0,06 хувийг иргэд эзэмшиж байна.

5 хувиас дээш хувьцаа эзэмшигчдийн нэрсийг дараах байдлаар харуулав. Үүнд:

№	Байгууллагын нэр	Эзэмшиж буй хувьцаа
1	Улаанбаатар Хотын Банк	28.66 %
2	Худалдаа Хөгжлийн Банк	25.65 %
3	Монгол Улсын Хөгжлийн Банк	14.88 %
4	Капитал Банк	8.12 %
5	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	7.50 %
6	Голомт Банк	5.57 %

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

"МИК Холдинг" ХК-ийн 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 16/22 тоот тогтоолоор 2015 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаандаа 241.2 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилахаар шийдвэрлэж, Ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тогтоосон. Ногдол ашгийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдэдээ 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хуваарилан шилжүүлсэн.



5. Санхүүгийн талаарх мэдээлэл

“МИК Холдинг” ХК-ийн хөрөнгө оруулалттай “МИК ОССК” ХХК нь 2016 оны эхний хагас жилд “МИК Актив Найм ТЗК” ХХК, “МИК Актив Ес ТЗК” ХХК-иудыг шинээр үүсгэн байгуулж, нийт 292,5 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргасан бөгөөд мөн хугацаанд МИК Актив Нэгээс Найм ТЗК ХХК-иас зөвхөн бонд эзэмшигчдэд 2016 оны эхний хагас жилийн байдлаар давуу эрхтэй бондын үндсэн төлбөрт нийт 72.04 тэрбум төгрөг, давуу болон энгийн бондын купоны төлбөрт 53,65 тэрбум төгрөг, үүнээс Ирээдүйн тэтгэврийн нөөц санд 43,95 тэрбум төгрөгийг нийт бондын үндсэн төлбөрт, 15,3 тэрбум төгрөгийг бондын купоны төлбөрт тус тус төлөөд байна.

**"МИК ХОЛДИНГ" ХК ГРУППИЙН 2016 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ
БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**


ХӨРӨНГӨ

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	103,757,509.54
Банкинд байршуулсан хадгаламж	45,697,453.22
Дансны авлага	402,220.55
Хөрөнгө оруулалт	125,078.32
Бусад санхүүгийн хөрөнгө /цэвэр/	2,251,565,486.05
Бусад санхүүгийн бус хөрөнгө	421,601.55
Үндсэн хөрөнгө	14,955,354.12
Биет бус хөрөнгө	59,847.37

НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН **2,416,984,550.72**

ӨР ТӨЛБӨР

Дансны өглөг	1,363,304.75
Хүүний өглөг	280,931.96
Бусад богино хугацаат өр төлбөр	4,403,146.13
Урт хугацаат зээл	8,440,772.06
Бусад урт хугацаат өр төлбөр	2,260,260,774.20

НИЙТ ӨР ТӨЛБӨР **2,274,748,929.09**

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувьцаат өмч	20,709,320.00
Нэмж төлөгдсөн капитал	52,225,114.83
Хуримтлагдсан ашиг	69,301,186.79
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	142,235,621.62

ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН **2,416,984,550.72**

Хүүгийн орлого	94,600,699.78
Хүүгийн зардал	56,080,767.35
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО	38,519,932.43
Хүүгийн бус орлого/зардал	(7,903,930.53)
Цэвэр ашиг	30,616,001.91

Нийт активын хэмжээ 2016 оны 06-р сарын 30-ны байдлаар 2,416.9 тэрбум төгрөгт хүрч, тайлант хугацаанд 94.6 тэрбум төгрөгийн орлого, 63,98 тэрбум төгрөгийн зардалтай ажилласнаар зээлийн үнэ цэнэ бууралтын зардлын өмнөх татварын дараах цэвэр ашгийг 30.6 тэрбум төгрөгт хүргэж ажилласан байна.



Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

Ашигт ажиллагаа

Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	1.30%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	21.50%

Өсөлтийн харьцаанууд

Нийт активын өсөлт	11.50%
Зээлийн багцын өсөлт	11.40%
Баталгаажсан бондын өсөлт	10.90%

Хөрөнгийн харьцааны үзүүлэлтүүд

Өөрийн хөрөнгө / Нийт хөрөнгө	5.90%
-------------------------------	-------

Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэмжээ нийт хөрөнгийн 93.5 хувийг, өөрийн хөрөнгийн хэмжээ 5.9 хувийг бүрдүүлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 11.5 хувиар өсөхөд ИЗББ-ын хэлцлийн хэмжээ 11.4 хувиар өссөн нь нөлөөлсөн.

2016 оны 06-р сарын 30-ны байдлаар активын өгөөж 1.3%, өөрийн хөрөнгийн өгөөж 21.5% тус тус үзүүлэлттэй байна.